



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

20 26 оны 4 сарын 29 өдөр

Улаанбаатар хот

1. ХУРЛЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хурал зарласан огноо: 2026/03/17

Хурлын төрөл: Ээлжит

Хурлын хэлбэр: live-р дамжуулан хуралдав.

Хурал болсон огноо, цаг: 2026.04.29-ний өдрийн 11:00 цаг

Хурал болсон газар: МИК-ийн байранд

Хурлын дарга: Чулуундоржийн Хашчулуун

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс		Хувьцаа эзэмшигчийн регистер/иргэний бүртгэлийн дугаар	Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо ширхэг
1		КАПИТРОН БАНК ХК	2677377	210,631
2	ДАМБАЧҮЛТЭМ	БАЙЛЫХҮҮ	111903720183	295
3		ХАС БАНК ХК	2578697	210,621
4		ХААН БАНК	2693321	210,621
5		ТӨРИЙН БАНК ХК	5341469	486,951
6		ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК	5251494	1,097,953
7	НЯМДАВАА	ЭРДЭНЭЧИМЭГ	111016481079	10
8		ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК ХК	2635534	2,070,932
9	ЛҮҮРЭН	ӨНӨРЖАРГАЛ	111612310514	1
10		СИ И СИ ГРУПП ХХК	5727138	488,750
11	ЖАДАМБА	ЭНХТУНГАЛАГ	110726181324	1
12		СИ ЭН БИ КОНСАЛТИНГ ГХО ХХК	6466257	2,608,480
13		ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	5479932	1,232,785
14		МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК	5461626	3,081,955
15		ГОЛОМТ БАНК ХК	2075377	1,023,033
16		АЗИА ДАЙВЕРСИФАЙД РИЙЛ ЭСТЭЙТ ФАНД НЭГ ХУВИЙН ХОС ХХК	6217125	2,312,500



Хурлаар асуудал:	хэлэлцсэн	1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай; 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай; 3. ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай; 4. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.
Хуралд оролцсон албан тушаалтан:		• Гүйцэтгэх захирал, Б.Гантулга; • Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Г.Сансар; • Бизнес хөгжил хариуцсан дэд захирал Ц.Батбаяр; • Эрсдэл хариуцсан дэд захирал Д.Отгонбилэг; • Санхүү хариуцсан дэд захирал М.Золжаргал; • ТУЗ-ийн Хараат бус гишүүн Э.Шижир; • “Эрнэст энд Янг Аудит Монголия” ХХК Партнер Д.Мандахбаяр, • Менежер М.Ундрал ТУЗ-ий ажлын алба: • Г.Саруул, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга; • Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч; Тооллогын комисс: • С.Амарсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын мэргэжилтэн; • Б.Тулга, “МИК ОССК” ХХК-ийн МТХ-Программ хөгжүүлэлтийн хэлтсийн Программ зохиогч • О.Төгөлдөрхурц, “МИК Холдинг” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн
Хурлын ирц:	98.61	

2. ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

Ч. Хашчулуун:	“МИК Холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс хурлын ирцийг танилцуулна уу.
С.Амарсайхан:	Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хуралд урьдчилан саналын хуудсаар 14,337,947 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 14 хувьцаа эзэмшигчид, хурлын цахим системээр 697,572 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 2 хувьцаа эзэмшигчид нэмэгдэж нийлбэр дүнгээр 15,035,519 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг нийт 16 хувьцаа эзэмшигч оролцсон нь нийт саналын эрхтэй 15,246,891 ширхэг энгийн хувьцааны 98.61% тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг хүчин төгөлдөр гэж Тооллогын комиссоос тогтоож, тус хурлын дарга (Ч.Хашчулуун)-д мэдээлсүгэй.
Ч.Хашчулуун:	Сайн байцгаана уу, “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 98.61 хувийн ирцтэйгээр эхэлж байна. “МИК Холдинг” ХК-ийн төлөөлөн удирдах

зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 26/07 дугаартай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тогтоолын дагуу тус хурал эхлэхэд бэлэн боллоо. “Эрнэст энд Янг Аудит Монголия” ХХК-ийн төлөөлөл болон “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Шижир нар мөн оролцож байна. Та бүхэн асууж тодруулах зүйл байвал аудитын компаниас асуух боломжтой. Хэлэлцэх асуудлыг дарааллын Б.Гантулга захирлыг урьж байна.

1 дүгээр асуудал: **Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай**

Б.Гантулга: Хувьцаа эзэмшигчид та бүрэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2026 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалын дагуу 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх тайланг танилцуулав.

Ч.Хашчулуун: Б.Гантулга захиралд баярлалаа. 2025 оны санхүүгийн тайланг “Эрнэст энд Янг Аудит Монголия” ХХК-ийн менежер М.Ундрал, Д. Мандахбаяр танилцуулна. Таныг урьж байна.

М.Ундрал: Сайн байцгаана уу,
Бид “МИК Холдинг” ХК болон түүний охин компаниудын 2025 оны 12 дугаар сарын 31-ий өдрөөрх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ий өдрийн байдлаарх Группийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу материаллаг алдаагүй, бодитой толилуулсан байна.**Дүгнэлтийн үндэслэл** Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Группээс хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна. *2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын танилцуулгыг дэлгэрэнгүй танилцуулав.*

Ч.Хашчулуун: Баярлалаа. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаад Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон

санхүүгийн тайлантай танилцаад дараах дүгнэлтийг гаргасан. “МИК Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, дугаар №26/06, 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр, Улаанбаатар хот, Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.7.15 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Санхүү, аудитын хорооны 2026 оны 3 дугаартай сарын 17-ны өдрийн 3 дугаартай дүгнэлтийг тус үндэслэн Тогтоох нь: 1. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй. 3. Энэ тогтоолын 2-т заасан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэн байгууллагад хүргүүлэн хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн ажлын алба (Г.Саруул)-нд үүрэг болгосугай. 4. Энэ тогтоолын 2-т заасан тайлангуудыг ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэр гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

2 дугаар асуудал:

Б.Гантулга:

Ногдол ашиг хуваарилах тухай

2024 оны 1 дүгээр улиралд 3 жилийн хугацаатай, 11.5%-ийн хүүтэй, 225 сая ам.долларын бондыг олон улсын санхүүгийн зах зээлд арилжаалсан бөгөөд Олон улсын хөрөнгө оруулагч нартай байгуулсан “Бондын нөхцөлийн гэрээ”-нд Үнэт цаас гаргагч “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК, Баталгаа гаргагч “МИК Холдинг” ХК нь хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахтай холбоотой 4.7 “Хязгаарлагдсан төлбөр” заасан байдаг. Үүнтэй холбоотой МИК Холдинг ХК нь 2026 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Ч.Хашчулуун:

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай тогтоолыг уншиж танилцуулъя. 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 26/03, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дахь хэсэг, Компанийн дүрмийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн “Ногдол ашгийн бодлого”-ын 3 дугаар зүйлийн 3.3, 3.5 дахь хэсэг, “Бондын нөхцөлт гэрээ”-ний 4.7 (а)-(с) хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь “МИК Холдинг” ХК нь 2026 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай. 1. Энэ тогтоолын 1-т заасан шийдвэрийн үндэслэлийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Хашчулуун)-д даалгасугай. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Санхүү, аудитын хороо (Э.Шижир)-нд даалгасугай.

3 дугаар асуудал:

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

- Ч.Хашчулуун: 2026 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны тайланг танилцуулав.
- 4 дүгээр асуудал: ТУЗ-ийн цалингийн зардлын төсвийг батлах тухай**
- Ч.Хашчулуун: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны хурлаас “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2027 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг нэмэхгүй өмнө жилтэй адил хэмжээтэй байхаар хэлэлцэж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулж дууслаа. Хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариултын цаг эхэлж байна.
- Ч.Хашчулуун: Асуулт хариултын цаг дууслаа. Хувьцаа эзэмшигчдээс асуулт ирээгүй байна. Өнөөдрийн хурлаас дараах тогтоолууд батлагдахаар байна. Тогтоолын төслийг 2026 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн материалд туссан байдлаар уншиж танилцуулав. Мөн хурлын дэгийн дагуу санал хураалтын үйл ажиллагаа эхэлж байна.
- Санал хураалт дууслаа. Санал хураалтын үр дүнг танилцуулахыг Тооллын комиссоос хүсэж байна.
- С.Амарсайхан: Санал хураалтад хурлын ирцэд бүртгэгдсэн 15,035,519 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 16 хувьцаа эзэмшигчид бүгд оролцсон ба санал хураалтын нэгтгэсэн дүнг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд мэдээлсүгэй. Үүнд:
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудалд:
- Нийт саналын эрхтэй 15,035,519 ширхэг хувьцаа эзэмшигчдээс санал хураалтын нийлбэр дүнгээр: Зөвшөөрсөн – 15,035,519 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид буюу 100 хувь, Татгалзсан – 0, Түдгэлзсэн – 0, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай асуудалд: Нийт саналын эрхтэй 15,035,519 ширхэг хувьцаа эзэмшигчдээс санал хураалтын нийлбэр дүнгээр: Зөвшөөрсөн – 15,035,519 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид буюу 100 хувь, Татгалзсан – 0, Түдгэлзсэн – 0.
- Ч.Хашчулуун: Тооллогын комисст баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагдсан тогтоолыг танилцуулав. Та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал үүгээр өндөрлөж байна.

3. ШИЙДВЭР, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ТОМЬЁОЛОЛ

Тогтоол-1

*Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 26/06 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:***

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Тогтоол-2

*Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2026 оны 3 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:***

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2026 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2027 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.САРУУЛ



[Signature]

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

[Signature]

Ч.ХАШЧУЛУУН